

БАТЛАВ:
ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ **/Д.ЦАНЛИГРЭНЧИН/**

Огноо: **2020.04.07**

БАГАЖ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: **ХӨАДСТӨХК/202001021**

МӨРӨН СУМ 2020 ОН

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Хөвсгөл Дулааны Станц ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Багаж хэрэгсэл**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04-р сарын 17-ны өдрийн 10 цаг 00 минут**-аас өмнө www.tender.gov.mn цахим системээр хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04-р сарын 17-ны өдрийн 10 цаг 10 минут** -т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх-үгүй

Тендерийн баримт бичгийг цахимаар хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50 000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

**Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, SB төвийн байр 4 давхар,
www.dulaan@khs.gov.mn
Харилцах утас: 7038-8489, 9901-9253**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жил буюу 2019 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт / 2. /Сүүлийн 1 жилийн /2019 он/ борлуулалтын дундаж хэмжээ санал болгож үнийн дүнгээс багагүй байх/ 3. Сүүлийн 1 жил /2019 он/ туршлагын мэдээлэл /ижил төстэй гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар /2-3/, гэрээ дүгнэсэн акт хамт/ 4. Аж ахуй нэгжийн товч танилцуулга 5. Улсын бүртгэлийн гэрчилгээ /эх хувь/ 6. Барааны жагсаалт, техникийн тодорхойлолт, үзүүлэлтийг гаргаж эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж ирүүлэх, 7. Бараан нийлүүлэлтийн хуваарь маягтын дагуу ирүүлэх 8. Ашигтай ажилласан байх-2019 он /www.tender.gov.mn Цахим сайтаас борлуулалтын орлогын хэмжээг тендерийн нээлт хийсэн өдрөөр татаж авна/ 9. Санал болгож буй барааны гарал үүслийг тодорхойлсон байх 10. НӨАТ-төлөгчийн гэрчилгээ /эх хувь/ <p>Бусад нэмэлт шаардлага; /2020 оны 04 дугаар сарын 05-ны өдрөөс хойш гаргаж ирүүлэх/</p> <ol style="list-style-type: none"> 11. Шүүхийн байгууллагын тодорхойлолт /эх хувь/ 12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /эх хувь/ 13. Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тодорхойлолт 14. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрсөн мэдэгдэл <p>www.tender.gov.mn цахим сайтаас тендерийн нээлт хийх өдрийн байдлаар татаж авах баримт бичгүүдийг нийлүүлэгч ирүүлэх шаардлагагүй бөгөөд дээрхи лавлагааг тбб-ыг бүрдэлд хавсаргана.</p> <ol style="list-style-type: none"> 15. Татварын тодорхойлолт /цахим лавлагаа, татварын өргүй байх/ 16. Санхүүгийн тайлан /цахим лавлагаа, тендерт оролцогчийн холбогдох чадавхын үнэлгээг хийхдээ холбогдох мэдээллийн баазаас дамжуулсан мэдээллийг үндэслэл болгоно/ <p>Жич: <i>Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно</i></p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх: шаардлагагүй</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг Мөрөн сум, SB төвийн байр, 4 давхар Давхар болон ерөөний дугаар: www.tender.gov.mn цахимаар Огноо: 2020 оны 04-р сарын 17-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг Мөрөн сум, SB төвийн байр, 4 давхар Давхар болон ерөөний дугаар: www.tender.gov.mn цахимаар Огноо: 2020 оны 04-р сарын 17-ны өдөр Цаг: 10 цаг 10 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <p>1.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>

1. **Барааны тодорхойлолт:** *Хөдөлмөр хамгааллын ажлын гутал*
2. **Стандарт:** *Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.*
3. **Баглаа, боодол:** *тоо ширхэг захиалгын дагуу бүрэн бүтэн, размерийн дагуу байна*
4. **Бараа хүргэх газар:** *Хөвсгөл Мөрөн сум, үйлдвэрийн хашаа склад*
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
	<i>Техникийн тодорхойлолтын дагуу</i>	<i>ширхэг</i>	<i>2</i>	<i>Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн үйлдвэрийн склад</i>	<i>Гэрээ байгуулагдсан өдрөөс 14 хоногийн дотор</i>	<i>2020.07.01</i>	

БАТЛАВ: "Хөвсгөл Дугааны Станц" ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирал  Д.Цанлигрэнчин



Үйлдвэрийн болон Цахилгаан, ДХХА-ийн сэлбэг багаж хэрэгсэлийн техникийн тодорхойлолт

№	Хийгдэх ажлууд	Х/Н	Тоо	Техникийн тодорхойлолт
1	А Шат /солонгос жижиг/	ш	1.0	Солонгос сунадаг/3-н гишгүүртэй/
	Дроцовны ком /6-32мм/	ш	1.0	TOTAL/industrial/, INGCO/industrial/- той дүйцэхүйц/6-32мм/
	Батарей дрилл Li-ion cordless drill 24V	ш	1.0	TOTAL LITHIUM IMPACT DRILL 20V 2.0Ah /дүйцэхүйц/ -ийн 2 ш батерейтай, цэнэглэгч, хуванцар цүнх дагалдана, Мушгилтын дагуу цохилттой, ажлын Лэд гэрэлтэй/
	Батарей тасдагч Li-ion cordless cutter 24V	ш	1.0	TOTAL Li-ion cordless cutter 20V дүйцэхүйц -ийн 2 ш батерейтай, цэнэглэгч, хуванцар цүнх дагалдана
	Түлхүүр ком 8-32	ш	1.0	TOTAL/industrial/, INGCO/industrial/- той дүйцэхүйц/6-32мм/
	Цохилттой дрилл кен	ш	1.0	TOTAL/industrial/, INGCO/industrial/- той дүйцэхүйц
	Таслагч кен	ш	1.0	KEN 9710 /710w/ дүйцэхүйц
	Дамартай уртасгагч УК50 50м	ш	1.0	IEK УК50 /50м/ дүйцэхүйц
	Түлхүүр ком 6-32mm	ком	1.0	TOTAL/industrial/, INGCO/industrial/- той дүйцэхүйц /6-32мм/
	Омметр UT502 Insulation resistance tester	ш	1.0	UT502 Insulation resistance tester
	Штангенциркуль электронн 30см	ш	1.0	электронн 350 /35см/
	Микрометр электронн	ш	1.0	электронн 0.01mm-0.25mm

Цахилгаан, ДХХА-ийн хэсгийн багаж хэрэгсэл

Түрдэг метр электронн	ш	1.0	Dmw30 Digital Measuring Wheel
Люксметр Extech 45170	ш	1.0	Extech 45170
Термометр Beha-Amprobe IR-450 Infrared Pocket Thermometer Details	ш	1.0	Beha-Amprobe IR-450 Infrared Pocket Thermometer Details
Хэлхээ шалгагч Klein Tools Non-Contact Voltage Tester with Infrared Thermometer-NCVT-4IR - The Home Depot	ш	1.0	Klein Tools Non-Contact Voltage Tester with Infrared Thermometer-NCVT-4IR - The Home Depot
Цахилгаан тоноглол шалгагч FLIR C3, Pocket-portable Thermal Imaging	ш	1.0	FLIR C3, Pocket-portable Thermal Imaging
Төгөсгөч шахагч 16-150мм	ш	1.0	16-150мм
Доргио хэмжигч /vibration meter UT315/ маркийн	ш	1.0	UT315/vibration meter/
Түлхүүр	ком	1.0	/8-36/орос/
Дорцов	ком	1.0	/8-32/орос/
Бахь	ш	3.0	ТАЈЕМА
Бахь нарийн хошуутай	ш	1.0	ТАЈЕМА
Кусочик	ш	1.0	ТАЈЕМА
Отверка	ш	12.0	ТАЈЕМА
Дроцовны ком	ш	1.0	ТАЈЕМА /6-32мм/
Гидер соёомик жижиг	ш	1.0	ТАЈЕМА 30тн
Гидер соёомик дунд	ш	1.0	ТАЈЕМА 50тн
Штангенциркуль	ш	2.0	ТАЈЕМА
Түлхүүр	ш	1.0	Орос нахтнатай 30 мм
Түлхүүр	ш	1.0	Орос нахтнатай 32 мм
Түлхүүр	ш	1.0	Орос нахтнатай 34 мм
Түлхүүр	ш	1.0	Орос нахтнатай 36 мм
Түлхүүр	ш	1.0	Орос нахтнатай 38 мм
Түлхүүр	ш	1.0	Орос нахтнатай 40 мм
Түлхүүр	ш	1.0	Орос нахтнатай 41 мм
Паранцусь	ш	4.0	32мм хүртэл
Плазмын хошуу	ш	100.0	/хошууны дм-1,5/
Плазмын гар	ш	1.0	LGK 100I
Конус артай өрөм	ком	2.0	/ф20-30/ орос
Тэгш ус 1м	ш	1.0	ТАЈЕМА /1м/
Метр 7,5	ш	3.0	ТАЈЕМА
Булан чий	ш	3.0	ТАЈЕМА
Домкрад 50 тн	ш	1.0	50тн
Домкрад 30 тн	ш	1.0	30тн
Домкрад 10 тн	ш	1.0	10тн

2

Үйлдвэрийн багаж хэрэгсэл

Цохилттой өрөм	ш	1.0	/Кен/
реза татагч	ш	1.0	/15-32/
пилта зүсэгч	ш	1.0	/кен/
PPR тэнь	ш	1.0	/15-32/
PVC хайч	ш	2.0	15-25
Уртасгагч /Кабель/	м	100.0	КГ-3х2.5 орос
Том тайрагч	ш	1.0	/кен/
Дунд тайрагч /кен/	ш	1.0	/кен/
Жижиг тайрагч /кен/	ш	3.0	/кен/
Гагнуурын аппарат /Үйлдвэр, ДДТ/	ш	2.0	/400А/ 220v380v
гагнуурын гар	ш	2.0	/сайн чанарын/
Гагнуурын баг	ш	6.0	хар өнгийн давхар шилтэй, түгжээ бэхэлгээ сайн байх
Гагнуурын запас шил	ш	60.0	С3-аас 50ш, С2-оос 10ш
Нэг голтой кабель	м	30.0	КГ-1х10 /хөлдөхгүй хугардаггүй байх/
Зөөврийн гэрэл	ш	6.0	Лед тусгал сайтай, стандарт патронтой
Зөөврийн гэрэлийн ламп	ш	80.0	Лед 24ватт - 36ватт
тайл 1тн	ш	1.0	гинжит, араат механизмтай
тайл 3тн	ш	1.0	гинжит, араат механизмтай
тайл 5тн	ш	1.0	гинжит, араат механизмтай
бүрээстэй тросс	м	20.0	10мм
бүрээстэй тросс	м	20.0	12мм
бүрээстэй тросс 1	м	20.0	14мм
Татлага олс 14мм	м	50.0	14мм бөөрөнхий, гүрмэл, даацын
Татлага олс 18мм	м	50.0	18мм бөөрөнхий, гүрмэл, даацын
Дамран уртасгагч	ш	1.0	50м
төмрийн хөрөө	ш	1.0	гар /ир салдаг/
яндан өрөм	ком	1.0	өрөмны ДМ-/63, 80,100,150/
том молдок	ш	1.0	220v
Шипрез /товуд/	ш	4.0	ТАЈЕМА
А Шат	ш	1.0	сайжруулсан хөнгөн цагаан хийцтэй 5-6 гишгүүртэй салдаг 180 градус дэлгэгддэг. /Солонгос/
Редукторон хаалт	ш	2.0	/ф250/ бөмбөлөг
Редукторон хаалт	ш	2.0	/ф200/ бөмбөлөг

3	Үйлдвэрийн сэлбэг хэрэгсэл	К-1 ийн тэжээгчийн цахилгаан хөдөлгүүр редуктор /ком/	ш	2.0	0.75кВт хөдлүүртэй, муфьтэн холбоотой, цахилгаан хөдөлгүүр түгээмэл байх.
		Том бутлуурын шарик, жижиг	ш	2.0	/22238CA/W33/
		Том бутлуурын шарик, том	ш	2.0	/22334CA/W33/
		Жижиг бутлуурын шарик жижиг	ш	1.0	/22324/
		Жижиг бутлуурын шарик том	ш	1.0	/22328/
		Сүлжээний насосны шарик	ш	50.0	/6308/
		Сүлжээний насосны сальник	ш	40.0	/109-40/
		Сүлжээний насосны гол	ш	2.0	зураг хавсаргав
		Шидэгчийн шарик	ш	40.0	/2307/
		Шарик	ш	10.0	/6309/
		галын тоосго	ш	200.0	галд тэсвэртэй
		галын тоосгоны /шаматны шавар/	дуудай	20.0	ширхэггүй нунтаг, тусгай зориулалтын бэхжүүлэгчтэй байх
		Шидэгчний ремен	ш	20.0	A1600
		Шидэгчний ремен	ш	30.0	A1400
		Шидэгчний ремен	ш	20.0	A600
		4	ХАБЭА	Үл буцах клапан d=76	ш
Дөрөө	хос			1	/0.4кВ/ /1номер/ орос цахилгааны /нурууны хамгаалалттай гулсахгүй бэхэлгээ түгжээ сайн байх/
өндрийн бүс	ш			1	цахилгааны /нурууны хамгаалалттай гулсахгүй бэхэлгээ түгжээ сайн байх/
монтёрын бүс	ш			1	цахилгааны /нурууны хамгаалалттай гулсахгүй бэхэлгээ түгжээ сайн байх/
дөрөөний тоног	хос			2	арьс ширэн
бахь	ком			5	ТАЈЕМА
амь олс	м			50	Ф16мм
индикатор/дуут/	ш			10	UNI-T UT12C
Отвертка	ком			5	10pcs/set
амперкlesh	ш			2	UNI-T UT202c
кусочке	ш			5	ТАЈЕМА
Жолоочийн иж бүрдэл	ком	10	галын хор, ослын гурвалжин 2ш, эмийн сан, чирэгч, дугуйн ивээс 4ш		

Хянасан Ерөнхий инженер Ш.Нямханд
Тодорхойлолт гаргасан Ашиглалтын инженер Л.Отгонбаяр
Цахилгааны инженер А.Мөнхболд

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[2020.04.17]

(Хөвсгөл Дулааны станц ТӨХК)-ын дарга Д.Цанлигрэнчин танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 6 сар байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор хийнэ. Урьдчилгаа төлбөр олгохгүй. Бараа тээвэрлэх зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцана. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1 Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагчаас томилсон комиссын гишүүд акт үйлдэн хүлээн авна. Шаардлагад нийцэхгүй тохиолдолд барааг нийлүүлэгчид буцаана. Гарах зардлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 1) Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
2) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
3) Барааны гарал үүслийн гэрчилгээ
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- Нийлүүлэгч нь тээвэрлэлтийн явцад эвдэрч гэмтсэн бараа гарсан тохиолдолд 100 хувь сольж нийлүүлэх ба үүнээс гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцана.
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[0,1]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,1]**
- Алдангийн нийт дүн: **[5]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]